

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ- СОНСОХ ДААЛГАВАР

Санамж:

- Эхийг мэдэрч, сонсож, ойлгоод асуултад хариулаарай.
 - Хариултын олон хувилбараас зөвхөн нэгийг сонгож, хариултын хуудсан дээр зааврын дагуу будаарай.
 - Зөв хариулт бүр 2 оноотой
1. Охин яагаад заавал аавыгаа бүжгэнд явуулах болсон бэ?
 - A. Аавыгаа бүжгэнд сургах гэж
 - B. Аавынхаа ирээдүйн сайн сайхны төлөө
 - C. Охин өөрийнхөө төлөө
 - D. Аавыгаа явуулчихаад ганцаараа үлдэхийн тулд
 - E. Аавдаа дургүй учраас
 2. Аав нь захидлыг охиноосоо нуусан шалтгаан нь юу вэ?
 - A. Ээж рүү нь явуулахыг хүсээгүй учир
 - B. Охиноо эх орондоо сургах гэж
 - C. Охиныхоо сэтгэлийг сэвтээхгүй гэсэндээ
 - D. Охиныгоо өөрөөсөө холдуулахыг хүсээгүй
 - E. Ээжийнх нь сайн сайхны төлөө
 3. Охин аавыгаа үнэлэх үнэлэмж нь юунаас болж өөрчлөгдсөн бэ?
 - A. Ээжийнхээ бичсэн захидлаас болсон
 - B. Бүжгэнд явсанаас болсон
 - C. Ганцаараа үлдэж зурагт үзсэнээс болсон
 - D. Өөрт нь тулгарсан зовлонг дотроо хадгалсан болохоор
 - E. Захидал нууснаас болсон
 4. Ээж нь хүний газарт хэрхэн, яаж амьдарч байгаа вэ?
 - A. Ганцаардаж байгаа
 - B. Яг өнчин юм шиг байгаа
 - C. Зовж зүдэрч байгаа
 - D. Амьдрах хүсэлгүй болж байгаа
 - E. Аз жаргалтай байгаа
 5. Охины ихээр хүссэн зүйл нь юу вэ?
 - A. Элэг бүтэн амьдрахыг
 - B. Аавыгаа бүжгэнд явуулахыг
 - C. Хэн нэгэн аавтай минь эргэлдэнхэн бүжиглээсэй гэж
 - D. Аав минь хүнтэй танилцаасай гэж
 - E. Ээжийгээ хурдан ирээсэй гэж

“Аавтай минь бүжиглээч” эхийн даалгаврын зөв хариулт

даалгавар	Зөв хариулт
1	B
2	C
3	A
4	B
5	C